

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дуламын Даширинчен	Дугаар	L011
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сүхбаатар дүүрэг
Төрсөн газар	Архангай аймгийн Тэрхийн цагаан нуур	Төрсөн он	1909
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Завхан аймгийн Яруугийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ЗААХ 070
Одоогийн сүм хийд	Дамбадаржаалин хийд	Сүм хийдийн дугаар	UB 07
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 15	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Завхан аймгийн Алдархаан сумын Яруугийн хүрээ

Би Завхан аймгийн Яруугийн хүрээнд 6 настайгаасаа 30 нас хүртлээ суусан хүн. Намайг 6 настай байхад ижий минь нас бараад нагац ахын дэргэд 24 жил болсон. Энэ 24 жилийн хугацаанд хийдийн хэрэмнээс гараагүй. Хүрээ хийд тараход л гарсан.

Яруугийн хүрээ Цанид-Чойр, Жүд, Мамба, Майдар, Дүйнхортой, 8 аймагтай, Дордовтой, 500-600 ламтай газар байсан. Энэ лам нарын ихэнх нь бадарчид. Ойр хавийнх нь нутгийн хойд хошуу, урд хошуу гэж даасан хошуу байхгүй. Гадна талаараа шавар хашаатай дотор талаараа шавар хэрэмтэй тийм газар байсан. Намайг гавжид тушаагдах жил сүм хийд устсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хүрээний хамба Шүхэр хамба гэж байсан. Тэр хамба хөдөөгийн жалганд нэг дуганын лам байж байгаад Яруугийн хүрээнд дуганаа авчраад суусан. Тэр үед Манжийн хаанаас тэр хамбад тамга өгч насан туршдаа тамгатай хутагт байх, дараагийн хүнээ өөрөө томилж байх эрх олгожээ. Тэр хөдөөгийн хийд нь цанид чойргүй сав шимиийн ном уншдаг газар байсан. Шүхэр хамба 150 гарсан хойноо нас барсан. Тэр Шүхэр хамба гэдэг хүний онцлог нь нүдний дээд тал нь зовхи нь буугаад таг болсон. Тэгсэн мөртлөө Лхамын шоо орхихдоо жигтэйхэн мэргэн. Хийдэд хурж байгаад нас барах болсон. Хойноо бурхантай, бурханыхаа урд ортой. Тэндээ суугаад эрхи эргүүлж байгаад байчхаад 2,3 алгаа ташаад, тэгээд хүнтэй дуугарахгүй 2,3 хоног болсон.

Миний нэг унзад багш Ванчин унзад гэж байсан. Багш намайг дагуулж тэр хамба дээр очлоо. Хамба багш их дураараа. Хамба архи хүртчихээд, архинаасаа бурхан руугаа тургиад байж байсан. Тийм танхай хүн. З жил мандал өргөсөн. Сүүлчийнхийг нь Хажидаас дуудлага ирсэн гээд хүлээж аваагүй. Шоголтой ном аваад унзад багшид өгсөн. Гэртээ очоод задлаад үзсэн. Ванчин унзад дуу алдсан. Миний сөхөж хараагүй ном хайлалаа. Дүмбаа Дэмбэн гэдэг нэртэй ном байсан. Энэ чинь ийм хүн байсан юм уу гээд. Тэгээд гэрт нь очиж шавь орж байсан.

Хамба хөдөөний нэг асман лам гэсэн нэртэй байсан. Нэг үзмэрч хүүхэд гарч. Хамба ямар ч хаалгаар орсон хажуугаараа ордог байсан. Тэгсэн энэ чинь эвэртэй юм байна гэж хэлж байсан.

Байсхийж байгаад л Барма зална гэдэг. Манай унзад багш цуг байна. Барма залахаар идэж уух юм айл болгоноос авна. Түмпэн дотор урт мээмтэй хар дүрстэй тэр нь өвдөг хүрсэн тийм юм олныг хийнэ. Бармыг ганцхан өөрөө зална. Нэг лагаа нөмрөөд л хийд дээрээ очно. Тэгээд Бармаа залчлаа. Нэг баахан урт хөхтэй дүрсээ л гал руу хийчлээ. Дараа нь сор залдаг. Тэрийгээ мөн залчлаа. Тэгсэн дараа нь ханиад томуу гараад, ганц нэг лам хороод тэгж байлаа. Ямар гээч Чойжин нь байсан юм бүү мэд.

Би Чойжлин гэсэн аймагт аймаглаж байсан. Жүдэд, Чойрт, Майдарт хурж байсан. Ер нь дугануудад цугааранд нь л хурж байсан. Цогчэн дуган гэж дээр үеийн хятад сүм байх. Тэнд 2,3 сараар томилогдон очиж хурдаг байсан. Манай хүрээ Улаанбаатар хоттой адилхан байршилтай. Хүрээний зүүн талаар Яруугийн гол урсана. Урдуур нь Богдын гол урсана. Урдаа Тэмээн Улаан гэдэг том уул, ардаа Майхан толгой нэрт уул, доод талдаа Хөх хошуу гэдэг шугуй тус тус байдаг. Яруугийн хүрээг Далай Чойнхор ван байгуулсан. Манжийн амбанд алба хааж байсан. Ахь Далай Чойнхор ванг байж байхад Ховдоос Ялгасан гэгээн гэдэг хүн хангайд бууя гэж газар гүйжээ. Далай Чойнхор ван газар өгдөг байж. Ялгасан гэгээний тухайд Ховдод нэг эмгэн, өвгөн хоёр дэrsэн дотор аргал түүгээд явж байсан. Хүүхэд орилоод байсан. Очсон нэг эрэгтэй хүүхэд нүцгэн хэвтэж байсан. Авч тэжээн өсгөсөн. Арван хэдтэй байхдаа нэг өдөр ус, сүү хоёрыг нь нийлүүлчихжээ. Хэдэн ямаатай, түүгээрээ амьдралаа залгуулдаг байж л дээ. Ээж нь зэмлэсэн. Эжий, эжий би ялгаад өгье, ялгаад өгье гэхэд чиний ялгадаг гэж юу байдаг юм гэсэн. Усны хувин, сүүний хувингаа тавьчих гэсэн. Гэтэл үнэхээр ялгасан. Тэр Ялгасан гэгээн хүрч ирж хийдийн сан сүнг нь тавьсан. Ялгасан гэгээний Чодон Чог гэж манай Цогчинд уншдаг. Нэг өдөр 10 хүртэл ч уншдаг байсан байх. Ялгасан гэгээн ахиад газар гүйсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өгөөгүй. Тэгсэн хормой дээр чинь шээж байгаад авна гэж хэлжээ. Тэр Ялгасан гэгээн бол хүнээс төрөөгүй хүйс байхгүй. Тэгээд таалал төгссөн. Сүүлд Далай вангийн хамаатныд очиж төрсөн.

Хошуу байгаагүй. Хятадын хар цэргийн хэрэм гэж байсан. Хойно болон урдаа нэг нэг хошуутай. Хойноо сартуул. Дандаа бадарчингууд ирж байсан. Сартуулын Бэйсийн хүрээ гэж их том 3000 ламтай хүрээ байсан. Би очиж байгаагүй.

Хүрээний гол сахиус нь Найчин, Цэдэв. Ядам нь Дамдин

Жигжид, Сэндом тахина. Жинхэнэ шүтдэг чойжин нь Гомбо.

Манайд сайн сайн лам нар олон байсан. Гүнжидлингийн дооромбо хамба гэж нэг хүн байсан. Ааш муутай. Хоёр шавь нь хоёул гавж. Сүүлд хоёр шавь нь баригдаад алуулаагүй. Бороог хамаагүй оруулна. Улиастайн ноёд ган болохлоор дооромбо хамбаас бороо оруулж хайрла гэж гүйдаг. Би чадахгүй гээд хадаг мадаг, мөнгө сангийг нь авдаггүй. Ноёдыг гүйхаар зөвшөөрдөггүй. Тэгсэн борчуулд нэг чавганц байсан. Тэр ядарсан муу чавганц даш хадаг гэж сармайсан хадаг бариад, бороо оруулж хайрла гэдэг. Тэр чавганцад бол зөвшөөрдөг. Хадгийг нь аваад өрхөө тэгшилж аргалаа бүтээ гээд зөөлхөн бороо оруулж өгдөг байсан. З хоног өдөр шөнөгүй ороод ус үерлэж сүйд болох дөхнө. Ноёд ирж бороогоо хариулж хайрла гэхээр би оруулсан юм биш гэж хэлээд өгсөн өргөл барьц, мөнгө төгрөгийг нь авдаггүй. Нөгөө чавганц хүрч ирдэг. Бороогоо хариулж хайрла гэж даш хадгаа барьдаг, хадгийг нь аваад өрхөө тат, аргалынхаа бүтээлгийг ав гэдэг байсан. Гэв гэнэт нар гарч бороо орохоо больдог тийм эрдэм мэдлэг, арга чаргатай хүн байсан.

Би Дилав хутагттай уулзаж шавь орж байсан. Манай зиндааныхан Дилав хутагтад мандал өргөж байсан юм. Манай хүрээнд Жалханз хутагт, Дилав хутагт, Нарванчин гэгээн нар очиж байсан. Манай хамба гэгээн, Ялгасан гэгээн хоёр бол ойролцоо насны хүмүүс байсан.

Мөн Адарсүрэн маарамба, Чунаг маарамба, Санжжав маарамба гэсэн алдартай эмч нар байсан. Улаанбаатарт залагдаж ирж Богдыг эмнэж, үзэж хардаг байсан.

Шүхэр хамбын дараа Чүлтэм гэдэг хүн хамба болсон. Гомбо гэдэг хүнийг шуумар нь гэж хэлдэг байсан. Сүүлд толгойлж байгаад баригдаад алуулсан.

Номын бар зөндөө байсан. Үйлдвэр байхгүй. Жасад байдаг байсан. Ганжуурыг төвдөөр тэндээ барлаж байсан. Тэнд их сонин хятадын амбаны нэг өрөө байсан. Тэр сүүлд хураагдаад түлэгдсэн байхдаа. Манай тэндхийн лам нар бол жинхэнэ лам. Зод, лүйжин тавьдаг хүмүүсийг хөөгөөд оруулдаггүй байсан. Цанид-Чойр, Жүд, Манба, Майдар, Дүйнхорын ном л үздэг байсан.

Манай Яруугийн хүрээ Богдын хүрээний дэгтэй байсан. Ер нь хүрээтэй тэrsэлдэж байсан шахуу юм байхгүй юу. Хамгийн сүүлд хүрээнээс Дашчойболын унзад Сандаг гэдэг хүн очиж хурал хурж байсан Нэг их том сайхан лам. Манай Яруугийн хүрээнд гавж болсон хүн Хүрээнд орж ирээд додь эргүүлээд суудал дээрээ суудаг. Тийм харилцаатай байсан. Энэ бол бусад газар байхгүй.

Яруугийн хүрээ бол Хятадын хар цэргийн байсан хашаа. Хэдийдээ ч тэнд байсан юм. Хэрмэн хашааны дээд талаар морь тэрэг явдаг доголтой. Хүрээнд нутгийн сартуул, бэйс нарын харьяатаас 80 хүн суудаг. 81 болвол заавал нэг нь хорогддог байсан. Бусад лам нар нь цөм бадарчингууд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байсан. Тийм газар байсан юм. Цам гардаггүй байсан. Цам байтугай зод, лүйжингийн талын юм ч байгаагүй. Жинхэнэ Цанид-Чойрын газар байсан.

Чойр дацанд хадаг /баруун, зүүн/, шидүв, жумбарай, юлжин, дондонжү, ог, гом, гавдамба, дом гээд 10 зиндаа, ум, сарва, умнямба, зод, ог-гаарамба, гаарамба гэсэн зиндаануудтай. Бүх зиндаа нь энэ. Тэгээд гавж болно. 15 жил сурдаг байсан. Нэг зиндаанд дээд тал нь 30-50 хүн байдаг байсан. Манай зиндаа 60-аад ламтай байсан. Зиндааны багш гэж байхгүй. Жорвон нь Гомбо гэдэг хүн байсан. Анги нь Гонгор гэдэг хүн байсан. Манай зиндаа бас их янзтай зиндаа, Дилав хутагтад мандал өргөж байсан юм. Зиндааны унзад Гантөмөр гэж нэг доголон хүн байсан. Мандал өргөхөд манай унзадаас давж гарах дуутай хүн байгаагүй. Гавжийг тушаагаад 3 жил болоод гавж болдог байсан юм. Би 1937 онд гавжид тушаагдах байсан. Чойр нь Гүнчэн ламын игчаатай. Дашчоймбол дацантай яг адил. Зөрөх юм байхгүй. Өөр хийдтэй харилцаа холбоо гээд байх юм байхгүй. Урд талын Бэйсийн, хойшоо Сартуулын хийдтэй ч холбоотой юм байгаагүй. Биеэ даасан.

Төвдөөс Сэтэв Чойжин гэж нэг чойжин ирж байсан. Миний хамт байсан нагац ах човомбо байсан. Хялаа Цолбо гэдэг хүн хоёр чомботой байсан. Хоёулаа ээлжилж тахил өргөдөг байсан. Хялаа Цолбо дуганд орой болохоор юм дуугараад байна гээд манай тэр нагацыг дагуулаад явжээ. Орсон хонх шажигнаад юм дуугараад байсан. Сэтэв Чойжин тэр өдөр Цанидын дуганд сахиусаа залсан гэсэн. Доод талын суудал нь хөдлөөд хажуу дахь хонхнууд нь дуугараад байсан гэж байгаа. Тэгж дугарсныг Сартуул ноён сонсоод өөрийнхөө хийдэд аваачиж сонирхож. Сартуулын дуганд Зэмэр Жэмэр гэдэг сахиусыг залахаар болсон. Чойжинг 4 баганаас төмөр гинжээр гинжлээд сахиусаа залахад дуган нь маш халуун болсон. Дотор нь байсан хүмүүс бүгд гараад явчихсан. Яг хоёр барим ган төмрөөр хутга хийгээд гурван талд нь ирлээд, тэрнийг өгсөнд барьж аваад татаад, зангидаад хаячихсан тийм чадалтай Чойжин байсан юм. Манай Цанидын дуганд үүднийх нь тэнд сэлэм аваачаад зангидаад тавьчихсан байдаг л байсан юм. Энэ бол нүдээрээ барин тавин харсан зүйлс юм.

Хийдийн байгууламжийн хувьд дан монгол маягийн модон дуганууд байсан. Харин цогчэн дуган, Ялгасан гэгээний дуган хоёр хятад хөх тоосгон дуган байсан. Бүгдийг нь Улиастай руу зөөгөөд байшин барьсан.

Жас сангийн хувьд нэгэн сонин түүх бий. Цагаан Оросууд орж ирсэн. Би 11, 12-той л байсан. Шүхэр хамба 7,8 хүүхэдтэй үлдсэн. Бусад хүмүүс бүгд зугтсан. Жасын гэр маш том, дотроо дөрвөн баганатай. Хамба бидэнд хүж, өөр барьдаг хийдэг юм юу байсан тэрийг хийлгээд өөрөө хонхoo дуугаргаад байж байсан. Орос цэргүүд баруун талаас хүрч ирээд, цугаараа мориноосоо буугаад жасын гэрт орж ирсэн. Жасын гэр зүүн талдаа дандаа шар олбогтой, баруун талд дандаа хөх олбогтой. Их баян жас байсан. Хүүхдүүд алах амьтан гэж мэдэхгүй чихэр жимс горьдож байсан байгаа. Тавагтай идээ засчихсан, идэж уух юмтай байсан. За тэгээд Шүхэр хамба Чоймбол няравт энэ улс ядарч яваа байх унаа мал хөсөг, хэрэгтэй юм болгоныг нь өг гэж тушаасан. Нярав айсан биз жа, жа гээд л байсан. Гэрийн хоймор том, том улаан авдартай. Нэг орос түлхүүрээ өг гэсэн. Түлхүүр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өгсөн. Өнөө авдруудыг гадаа авч гарсан. Тэр доторхийг бүгдийг нь юулээд авсан биз. Бид ч орой болоход гэр гэрээдээ явсан. Маргааш нь энд тэндгүй мөсөн чихэр, цасан чихэр, чавга гээд тамтаггүй их юм овоолоостой байсан. Тэд 2 хоноод, 3 дахь хоног дээрээ явсан. Тэгэхдээ жасын хөрөнгөнөөс 100 тэмээ ачаа авч явсан. Идэх хонь мал гээд бүгдийг авч явсан. Том лам нарын гэр хашаагаар нэг ч ороогүй ганцхан жасаас л юм аваад явсан. Мятив да ламыг барьж аваад явсан. Мөн Чоймбол няравыг, Чоёон гэдэг хүүхдийг аваад явсан. Чоймбол нярав гэж шулга хүн байсан. Давхар байшингийнхаа ар талыг онгойлгосон чинь дандаа дээр үеийн оросын хувцас зэндөө гарсан. Чоймбол няравт нэг буу байсан. Түүнийг хараад орос “Чоймбоол чи яаж байна?”, “Чоймбоол чи яаж байна?” гэж хэлж байсныг нь одоо болтол би мартдаггүй юм. Тэр авч явсан хүмүүсийг Тарган баатар вангийнх гэж Говь-Алтай аймагт аваачаад алчихсан юм.

Тэгээд Хатанбаатар араас нь явсан. Гол үерлээд 2, 3 хоног saatсан. Ингэж байх хооронд цаадуул нь авч явсан улсаа алсан юм байгаа биз. Тэнд нэг хөгийн юм болсон юм. Нэг төвд лам байсан. Нэг тахидаг цэргийн туг шиг юм байсныг нандин юм гэж хадгалж байсан. Тэр төвд лам энийг гарга гээд гадаа гаргуулсан. Гэрийн гаднаас уя гэсэн. Ламаа явсных нь дараа дуганд оруулсан. Тэрнээс улбаалж тэр хийдийг сүйтгэсэн гэж байгаа.

Лам нар татвар өгдөг байсан. Татварыг Улиастайд Ардын засагт төлдөг байсан. Ардын засгийн газар тамтаггүй их юм авсан даа. Бүх л хийд адилхан. Ялгасан гэгээний суврага цул алт байсан. Мөнгөн бурхан гээд тоо томшгүй. Одоо яриад ч яах вэ. Хамаг Монголын хөрөнгийг Орос л авсан байх даа.

Лам нар хүрээн дотроо нэг нэг жижиг гэртэй. Хашааны 4 буландаа 4 худагтай. Жас тусдаа худагтай, Манба тусдаа худагтай байсан. Хэрмэн хашаан дотор 450 жижиг гэр багтаж байсан байх. Тэгээд дуганууд, мөн аймгийн дуганууд байсан. Аймгийн дуганууд нь одоогийн Гандангийн хурал хурж байгаа дугантай адил хэмжээтэй байсан.

Нэг лам өвлийн идшиндээ гэдэс дотортой нэг хонины мах авдаг байсан. Нэг хавирга хоёр өдрийн хоол болдог байсан. Толгой нь нэг өдрийн бөгс /хавирганы/ нь нэг өдрийнх болдог байсан. Хоолны тал дээр нарийн гэж жигтэйхэн. Би тийм юманд өссөн. Ганц хар хавиргаар хоёр хүн хоол хийгээд аяга, аяга шар будаа идчихнэ. Өглөө нэг аяга хар цай, булан хавсай өдөр хоолоо идээд, нэг аяга хар цай. Үдээс хойш бол юм идэж ууна гэж байхгүй. Номоо л үзнэ. Тэгээд хуралдаа хурна. Жинхэнэ ламын талын тухай ярих юм бол өнөөдөр алга. Дээрээ ч алга. Доороо ч алга. Үсгээ л гаргаж уншиж байгаа бол дээдийн заяа болж дээ.

Хүрээ хийдэд эмэгтэй хүн хонохгүй. Номоо уншуулчихаад, мөргөж залбирчихаад л яваад өгнө. Сүсэгтнууд цагаан сараас хойш 15 хоногт их ирнэ. Тэр их сонин. Цагаан сарын дараа бид уутаа бариад очно. Лам нарт бор гурил өгнө. Тос, бор гурил хоёрыг нь ялган хадгалж жилийн аяганы хийц болно. Улиастай тариалан ихтэй. Тэр үеийн бор гурил одоогийнхыг бодоход тас хар өнгөтэй байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чойрт сард 15 хоног өдөр тутам хураад 15 хоног тасардаг байсан. Чойр дацандаа 15 хоног номоо үзнэ. Өвөл 30 хоног хурна. Чойр өдөр бүр нэг л хурна. Гүнчэ өвлийн сард нэг сар хурна. Цогчин өдөр бүр хурна.

Цогчинд 3-4 хүүхэд сарын хугацаатай очоод өдөр бүр уншина.

Жилийн дүйчэнгүүдэд Бурхан багшийн дүйчэн, Зулын 25, зуны дунд сарын 15 гэж хурна. Чойжингийн сор жилдээ нэг удаа, Найман аймаг намар тус тусдаа 3,3 хоног хурал хурна. Тэндээ аймгууд сор ч залдаг байсан.

Манай хүрээнд Майдар эргэдэггүй байсан. Хайллан хурдаг байсан. Хайланд гэцэл гэлэнгүүд хурна.

Ганжуурыг байнга айлтгаж уншуулж байдаг байсан. Нэг сонин юм гэвэл борчуулын тэнд овоохойтой нэг хөгшин чавганц байдаг байсан. Тэр чавганц яадаг юм бэ гэхээр өдөрт нэг хуймаг, домбо барьчихсан, нэг уут дүүжилчихсэн, Цанидын үүдэнд очоод өвөл ч адил зун ч адил мөргөнө. Тэгээд манж, цав бариад явахаар үлдэгдлээс нь саванд нь хийж өгөөд хооллодог байсан. Нэг удаа хуралд сууж байтал гэсгүй багана цохисон. Багана цохиход ямар ч хурал зогсоно. Тэгсэн айлтгал хэллээ. Тэр чавганцын нэрийг хэлээд 10 хайрцаг шүдэнз, 10 уастай зүү барьж Ганжуур айлтгалаа гэж 7 удаа гэсгүй ингэж зарлаж байсан юм.

Би гол мөрөнд суудаг хүүхэд байлаа. Номоо сайн цээжилсэн хүүхдийг тэнд суулгана шүү дээ. Нэг өдөр 8 хүүхдийг гэсгүй босголоо. Та нар гадаа гар гэсэн. Гараад очсон 8 тэмээ ачаа дуганын үүдэнд байж байна. Нэг тэмээний бурантаг бариад зогссон. Их баян хүн 8 тэмээ ачаатай ирж жасад өгөөд, өөрөө хадаг барьж Ганжуураа айлтгачихаад цавтай, манжтай 3 хоногийн хурал даачихаад яваад өгч байсан. Энэ бол их өгсөн бага өгсөн гэж ялгахгүй. Арга байхгүй ламын ёсоор байсны илрэл мөн.

Ганжуураар нутаг эргэнэ гэж тусгай хэдэн лам нар явдаг байсан. Жилдээ нэг удаа дулаан цагт явдаг байсан байх.

Би гол мөрөнд сууж байгаад гол хаалга руу харлаа гэж бэрээдүүлж байсан. Өвөлд дуган маш хүйтэн. Дээд тал нь 50 фу хүрч байсан гэж дуулдаж байсан. Дээр үед градусыг фу гэж хэлдэг байсан. Оруулж ирж байгаа манж, цавны дээгүүр бор шувууны мөр гарчаад орж ирдэг байсан. Хүйтэн байна гэвэл дуганын хаалгаа нээчихдаг байсан. Биднийг ном уншихгүй үедээ хамрынхаа үзүүрийг хараад сууж бай гэдэг байсан. Хаалга үүд рүү орж ирж байгаа хүмүүсийг харж болохгүй гэдэг байсан. Савтай цогийг том лам нарын өмнө л тавина. Хүүхдүүдэд хүртээлгүй. Дунд тавихгүй. Өөр халаалт байхгүй.

Хүрээний ойролцоо худалдаа найманы газар байгаагүй.

Хийдийн орчмын борчууд хийдээс 10-20 км-н зайдай байсан.

Хүрээ хаагдахад яг тэр хаагдах өдөр дугандаа ороогүй. Ванчин унзад тэргүүлэн нэг хурал хураад жанчaa дуган дотроо тавиад гарсан гэсэн. Би өмнөх өдөр нь тавьсан байсан. Тэр өдөр сумын захиргаан дээр очиж хар болох үнэмлэхээ авч байлаа. Нураахад нь би байгаагүй. 1938, 1939 оны үед нураасан. Би оргоод явсан. Миний нагац ах баригдаад Улиастайд 20 хоноод буудуулсан. Гэрийн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

доторх юманд гар хүрч болохгүй лацадчихсан. Гэтэл нэг өдөр нэг ногоон малгайтай хүн, Далбаарагчаа гэдэг таньдаг хүнтэй гурвуул орж ирсэн. Одоо бодоход 5 сард юм шиг байна. Нөгөө ногоон малгайтай хүн бурханы урдуур яваад над руу муухай харж байсан. Би намайг алах нь гэж бодсон. Түлхүүрээ гэсэн. Аваад өгсөн. Яв гэсэн. Ердөө л ингэж хэлсэн. Хаашаа ч явахыг бүү мэд. Өмсч байсан өвлийн гуталны ширэн ул нь цоорчихсон. Эсгий оймстой, өмд байхгүй, банзалтай, нэг муу нимгэн цамцтай, дал мөр нь цайсан дан тэрлэгтэй гарсан. Улиастайгаас мал тууж Хатгал ороод 1938 онд тэндээ өвөлжөөд Хатгалаасаа энд ирсэн. Хатгалд байхдаа цагдаа болсон мөн тэндхийн анхны жолооч болсон. Жолоочийн сургуульд хүн авч байна гэхээр нь цагдаа хувцастайгаа яваад очсон. Нэг өдөр яваад очсон хичээл зааж байсан багш нар бүгд баригдаад ганцхан коминдат үлдсэн байсан. Анх Архангай аймагт шуудан хүргэхээр гарч байлаа. 1946 онд Намын сургуулийн захирал Доржэев гэдэг хүн байлаа. Сургуульд сур л гэдэг байсан. Би дарга болох хүсэл байхгүй гэж хэлж байсан. 1944 оноос хойш Намын дээд сургуульд 27, 28 жил аж ахуйн албаны дарга хийсэн. 1990 онд тэтгэвэртээ гарсан. Яруугийн Хүрээнээс хотод орж ирсэн лам нартайгаа уулзаж байсан. Гэхдээ хурал ном, шашны талаар ярьж байгаагүй. Яривал буудуулах байсан.

Тэгээд Сандаг, Очиржав, Баатар нартай хамтран дөрвүүл Дамбын хийдийг сэргээн хурж байна. Тэгээд нэг хэсэг настай хүмүүсийг цуглуулаад тэрний хүчээр одоо хийд гээд байж байна. Лам хүн бол наймаа арилжаа бодож, юм хураахын хойноос явдаг юм биш. Лам хүн өөрийгөө өөд нь татах үүрэгтэй. Хүнд нэг цагаан, нэг хар зам бий. Энэ хоёр нэг л саванд байдаг.

Одоо хамба нэртэй байгаа. Нэг хэсэг надаас залуучууд булааж авч дэлгүүр гаргаж, янз бурийн юм хийх гэж баахан оролдож хөөцөлдөөд одоо л нэг намдаж байна уу, үгүй юу мэдэхгүй. Би энэ хамбыг урьдын хуучныхаа ёсоор шилжүүлж, тамгаа өгнө гэж бодож байгаа. Наана нь хэнд ч өгөхгүй. Өгч чадах ч үгүй гэж бодож байгаа.